



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2013 оны 01 сарын 23 өдөр

Дугаар 33

Улаанбаатар хот

Даатгалын байгууллага, даатгалын мэргэжлийн оролцогчид
аудит хийх эрхийг сэргээх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, Даатгалын тухай хуулийн 33.2.2, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 20.2.2 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2010 оны 149 дүгээр тогтоолоор батлагдсан "Даатгалын байгууллагад аудит хийх үйл ажиллагааг зохицуулах журам"-ын 2.9 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ НЬ:

1. "Ситико-Аудит" ХХК гаргасан зөрчлөө түдгэлзүүлсэн хугацаанд бүрэн арилгасан тул даатгалын байгууллага, даатгалын мэргэжлийн оролцогчид аудит хийх эрхийг сэргээсүгэй.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын албаны дарга (Х.Бум-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000013